*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

# ЧАНАР ХЯНАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ОЮУНЧИМЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар

Нэгжийн нэр: Чанар хяналтын газар

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо /60 хүртэл/ | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал /10 хүртэл/ | Нийлбэр оноо /70 хүртэл/ | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| **“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 5.3.11, ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН 6.1.1, МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 5.2.1, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.3.1.1, 4.3.1.4** | | | | | |
| **Зорилт 1: “Төрийн цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | |
| 1. | Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой салбар дундын зохицуулалт хийх байгууллагатай уулзалт зохион байгуулах; | 56 | 10 | 66 | 66 |
| 2. | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, дүгнэх ажлыг зохион байгуулах; | 60 | 10 | 70 | 70 |
| **Зорилт 2: “Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | |
| 3. | Нээлттэй мэдээллийн системийн талаар мэдээлэл хариуцагч байгууллагуудад сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах; | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д шилэн индексийн тайлан илгээх, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх чиглэлээр контент бэлтгэх, мэдээлэл хариуцагч байгууллагуудад түгээх ажлыг зохион байгуулах; | 60 | 10 | 70 | 70 |
| 5. | Хүн, хуулийн этгээдээс тусгай дугаараар болон бусад хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх, хяналт тавих; | 56 | 10 | 66 | 70 |
| **Зорилт 3: “Төрийн цахим үйлчилгээнд инновац, дэвшилтэт технологи (дижитал)-ийг нэвтрүүлж системийн интеграци хийх” зорилтын хүрээнд** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6. | Төрийн цахим үйлчилгээний процессын дахин инженерчлэлийг зохион байгуулалтаар хангах; | 56 | 10 | 66 | 66 |
| 7. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д мэдээлэл хариуцагч байгууллагын шилэн индексийн тайлан илгээх, хүлээн авах, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх байдалд хяналт тавих, хяналтын тогтолцоог сайжруулах ажлыг зохион байгуулах; | 60 | 10 | 70 | 70 |
| 8. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д мэдээлэл хариуцагч байгууллагын байршуулсан "Шилэн индекс"-ийн тайланг үнэлсэн, хянан баталгаажуулсан эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд хийх хяналт, шалгалтын удирдамж боловсруулах, хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх; | 50 | 10 | 60 | 70 |
| 9. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаа, үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэхэд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, зөвлөмж хүргүүлэх; | 60 | 10 | 70 | 70 |
| 10. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаанд хяналтын камераар хяналт хийх хуваарийг боловсруулан батлуулах, өөрийн хариуцсан цэгт хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах; | 60 | 10 | 70 | 70 |
| 11. | Газрын үйл ажиллагаа, хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор хүргэх "ХУРДАН" цэгт мэдээллийн аюулгүй байдлын аудитыг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдээр хийлгэх, зөвлөн туслах үйлчилгээ авах ажлыг зохион байгуулах; | 60 | 10 | 70 | 70 |
| 12. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хөгжүүлэлтийн явцад хяналт тавих, ХУРДАН цэгийн техник тоног төхөөрөмж, программ хангамж, сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлэх; | 57 | 10 | 67 | 67 |
| **Зорилт 4: "байгууллагын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх" зорилтын хүрээнд** | | | | | |
| 13. | Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль, тогтоолын төсөлд санал өгөх; | 56 | 10 | 66 | 66 |
| 14. | Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлуулж, биелэлтийг хангах; | 60 | 10 | 70 | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15. | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмын хэрэгжилтийг ханган ажиллах; | 60 | 10 | 70 | 70 |
| 16. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах; | 60 | 10 | 70 | 70 |
| **Хоёр. Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны А/53 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах (Эцэг, эхийн зөвлөл); | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны А/99 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах; | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Процессын дахин инженерчлэл зангиагүй уулзалтаас гарсан санаануудаар танилцуулга бэлтгэх; | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | Чанар хяналтын газраас 2025 онд хийгдэх ажлын танилцуулга бэлтгэх; | 60 | 10 | 70 | 70 |
| 5. | Хяналт, шалгалтын чиглэлээр 2024 онд хийсэн ажлын нэгдсэн тайланг боловсруулах; | 60 | 10 | 70 | 70 |
| 6. | Хороонд байрлах ХУРДАН цэгт хийсэн хяналт, шалгалтын тайлан танилцуулах; | 60 | 10 | 70 | 70 |
| 7. | Мэдээллийн аюулгүй байдлын аудитын талаар ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг нийт газрын дарга нарт албан мэйлээр хүргүүлэх; | 60 | 10 | 70 | 70 |
| 8. | Агентлагийн албан хаагчдад сургалт хийх хуваарь гаргах; | 60 | 10 | 70 | 70 |
| 9. | Аймаг, нийслэл рүү явуулсан киоскийн албан бичгийн судалгааг авч дуусгах ажлыг Систем нэгтгэлийн хэлтэстэй хамтран 5 дугаар сард багтааж дуусгах; | 60 | 10 | 70 | 70 |
| 10. | И Монгол Академи Улсын төсөвт үйлдвэрийн газартай shilen.gov.mn, gov.mn-тэй холбох асуудлаар уулзалт зохион байгуулах; | 60 | 10 | 70 | 70 |
| 11. | Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлэх Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн товч тайланг боловсруулах, хүргүүлэх; | 60 | 10 | 70 | 70 |
| 12. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Сайдын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" А/59 дүгээр тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг гаргаж Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлэх; | 60 | 10 | 70 | 70 |
| 13. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn) 2.0 хувилбарын "Шилэн индекс"-ийн тайланд хийсэн үнэлгээний талаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас 2025 оны 1 дүгээр удирдлагад хийсэн ажлын тайланг Цахим хөгжил, | 60 | 10 | 70 | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлэх. | | | | |
| **Дундаж оноо:** | | | | 69 | 69 |

**17. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| 1. | Байгууллагаас болон бусад газраас зохион байгуулах сургалтад хамрагдана. | 73.3 | 11 | 11 |
| **Дундаж оноо** | | | 11 | 11 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 6 | 6 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | 6 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 6 | 6 |
| 4. | Хариуцлагатай байдал | 6 | 6 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 6 | 6 |
| **Дундаж оноо** | | 6 | 6 |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 7 |
| 2. | Багаар ажиллах | 7 |
| 3. | Харилцаа | 7 |
| **Дундаж оноо** | | 7 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 69 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 11 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | 6 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 7 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | 93 |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 93 |

***Үнэлгээ өгсөн:*** **Нэгжийн дарга**

Чанар хяналтын газрын дарга ..................... /И.Хайратбек/

*2025.06.06*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** **Төрийн жинхэнэ албан хаагч:**

Чанар хяналтын газрын
Ахлах мэргэжилтэн ..................... /Д.Оюунчимэг/

*2025.06.10*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*
Нийслэл хариуцсан хэлтсийн дарга ..................... /Ж.Даваасүрэн/

*2025.06.20*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

Захиргаа удирдлагын газрын
Хүний нөөцийн мэргэжилтэн ..................... /Б.Номин/

*2025.06.20*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** **Төсвийн шууд захирагч**

Төрийн цахим үйлчилгээний
зохицуулалтын газрын дарга ..................... /П.Батбаатар/

*2025.06.23*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ЧАНАР ХЯНАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ОЮУНЧИМЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| **“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 5.3.11, ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН 6.1.1, МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 5.2.1, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.3.1.1, 4.3.1.4** | | | | | | | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ** | | | | | | | |
| 1.1. | Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой салбар дундын зохицуулалт хийх байгууллагатай уулзалт зохион байгуулах; | Хамтран ажиллах байгууллагын тоо | 56 | 5 | Төрийн үйлчилгээний нэгдсэн системд үйлчилгээ нэвтрүүлэх чиглэлээр Үндэсний статистикийн хороо, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Цагдаагийн ерөнхий газрын Стратеги, бодлого, инновац, хөгжлийн алба, И-Монгол академи Улсын төсөвт үйлдвэрийн газар, Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газар, Гэрэгэ киоск ХХК, Ай Эм Си Эй ХХК, ЭМ АЙ СИ ЖИ ХХК, Австралийн Прайм Би Пи Эм ХХК-ийн суурин төлөөлөгч Infosolution ХХК зэрэг 10 байгууллагуудтай зохион байгуулсан уулзалтад оролцсон. | 01-12 | 50 |
| | | Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх тоо | - | 1 | Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын “Шилэн индекс”-ийн тайлангийн 5 бүлэг 87 шалгуур | 06-12 | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлэлтийг файл, зурагтай байх эсэх дээр санал боловсруулан 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны холбогдох газарт хүргүүлсэн. | | |
| 1.2. | Төрийн цахим үйлчилгээг дахин загварчлах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хүрээнд мэдээлэл хариуцагч байгууллагуудтай уулзалт зохион байгуулах; | Мэдээлэл хариуцагч байгууллагын тоо | 2 | 1 | Төрийн цахим үйлчилгээг дахин загварчлах ажлын хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газар, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Гамшиг судлалын үндэсний хүрээлэнтэй уулзалт зохион байгуулж, уулзалтаар Жижиг, дунд үйлдвэрийн газрын жижиг, дунд, үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох (сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих), жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг бүртгүүлэх (тодорхойлолт олгох, авах) 2 үйлчилгээ, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн химийн лабораторийн дүгнэлт гаргах, химийн лабораторийн сорилтын дүнгийн хариу авах 2 үйлчилгээ, нийт 4 үйлчилгээг Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаг 2” төслийн хүрээнд цахим хэлбэрт шилжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр дамжуулан үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үйлчилгээний чанарыг сайжруулах судалгааг боловсруулсан талаар дэлгэрэнгүй болон товч тайланг хянан засварлаж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/376 дугаар албан бичгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **АЛСЫН ХАРАА 2050-ЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 5.3.5, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.3.3.6, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.1.2.8** | | | | | | | |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 2: БҮХ НИЙТИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| 2.1. | Нээлттэй мэдээллийн системийн талаар мэдээлэл хариуцагч байгууллагуудад сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах; | Хамрагдсан албан хаагчийн тоо | 500 | 500 | Засгийн газрын “Шил” ажиллагааны хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарын сургалтыг Гаалийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн харьяа байгууллагууд, Баян-өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн харьяа боловсролын газар, хэлтэс, сургууль, цэцэрлэг, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам зэрэг 4 нийт 455 албан хаагчдад танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан.<br>“Шилэн индекс”-ийн тайланг хүлээн авч, хянах, үнэлэх, баталгаажуулах нээлттэй мэдээллийн дата оруулах, шинэчлэх, байгууллага бүртгэх, системд хандах эрх нээх зэрэг асуудлаар мэдээлэл хариуцагч байгууллагын 136 албан хаагчдад зөвлөгөө, мэдээллийг 70122626 тусгай дугаарын утас, цахим орчин, албан хаагчийн хувийн (гар утасны дугаар) харилцааны хэрэгслээр, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын цахим хуудас болон youtube.com платформд байршуулан нийт 6215 хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө, мэдээллийг хүргэж ажилласан. | 01-12 | 100 |
| 2.2. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д шилэн индексийн тайлан илгээх, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх чиглэлээр контент | Хандалтын тоо | - | 500 | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д шилэн индексийн тайлан илгээх, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх, мэдээлэл шинэчлэх чиглэлээр цуврал 3 контент бэлтгэн | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэх, мэдээлэл хариуцагч байгууллагуудад түгээх ажлыг зохион байгуулах; | | | | мэдээлэл хариуцагч байгууллагуудад хүргэх ажлыг зохион байгуулж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын цахим хуудас болон youtube.com платформд байршуулан нийт 24857 хүн, хуулийн этгээдэд мэдээллийг хүргэж ажилласан.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн (shilen.gov.mn) системд "Шилэн индекс"-ийн тайлан илгээх, байршуулах асуудлаар Монголын үндэсний олон нийтийн телевиз, Eagle Телевизийн зочны цагт оролцон мэдээлэл өгсөн. | | |
| 2.3. | Хүн, хуулийн этгээдээс тусгай дугаараар болон бусад хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх, хяналт тавих; | Хүсэлт хүлээн авсан тоо | 662 | 166 | Тайлант хугацаанд 7012-2626 тусгай дугаарт Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-тэй холбоотой асуудлаар 17 дуудлагыг хүлээн авч, зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан.<br>Мөн 70122626 тусгай дугаарын утасны дуудлагын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 хувиар буурсан нь утасны дуудлагыг "төрийн цахим үйлчилгээ, нийслэл дэх ХУРДАН цэг, киоск машины байршил, цагийн хуваарь, аймаг дахь ХУРДАН цэг, киоск машины байршил, цагийн хуваарь, үйлчилгээний ажилтантай холбоотой санал гомдол, талархал, цахим ур чадварын сургалт, Нээлттэй мэдээлэл систем shilen.gov.mn-ийн үнэлгээ, цахим ур чадварын сургалт, байгууллагын бичиг хэрэг, систем" гэж 9 хэсэгт ангилан хувааснаар 1 газарт оногдох дуудлагын тоо буурсан, мөн цахим орчин (Shilen all, хувь viber chat), хувь албан хаагчийн харилцааны хэрэгсэл (гар утас) -ээр зөвлөгөө, | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийг өгч байгаатай холбоотой байна. | | |
| | | Зөвлөгөө мэдээллийн тоо | 300 | 100 | Тайлант хугацаанд 7012-2626 тусгай дугаарт Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-тэй холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авахаар хандсан 17 албан хаагч, цахим орчин (Shilen all, хувь viber chat), хувь албан хаагчийн харилцааны хэрэгсэл (гар утас)-ээр хандсан 121 албан хаагч, нийт 138 хүн, хуулийн этгээдийг зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан. | 01-12 | 70 |
| **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.2.2.1, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.1.2.5** | | | | | | | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНД ИННОВАЦ, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ (ДИЖИТАЛ)-ИЙГ НЭВТРҮҮЛЖ СИСТЕМИЙН ИНТЕГРАЦИ ХИЙХ** | | | | | | | |
| 3.1. | Төрийн цахим үйлчилгээний процессын дахин инженерчлэлийг зохион байгуулалтаар хангах; | Дахин инженерчлэл хийгдсэн байгууллагын тоо | 1 | 1 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар 2024 оны дөрөвдүгээр сараас эхлэн "Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв" ТӨҮГ болон "Систем Арт Венчурс" ХХК-тай хамтран "Жижиг, дунд үйлдвэрийн газар"-аас хүн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийсэн ажлын үр дүнд боловсруулсан тайланг газрын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/36 дугаар албан бичгээр Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлсэн.<br>Процессын дахин инженерчлэл хийхэд тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар р "Процессын дахин инженерчлэл" сэдэвт хэлэлцүүлгийн хөтөлбөр, оролцох байгууллагын хуваарийг гарган, холбогдох албан хаагчдыг зөвлөгөө, мэдээллээр хангаж, уулзалтын мэдээллийг цахим хэлбэр болон гар утсаар хүргэх ажлыг хийж гүйцэтгэн 2025 | 01-12 | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны 01 дүгээр сарын 24-ний өдөр хэлэлцүүлгийг зохион байгуулж, хувийн хэвшлийн 12 байгууллага хамрагдан, процессын дахин инженерчлэлийн талаар санал солилцох, туршлага судлах, практик шийдлүүдийг хуваалцах зэрэг асуудлаар санал солилцсон.<br>Австрали Улсын “Прайм бизнес процессын менежмент” компанийн төлөөлөлтэй 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр уулзалт зохион байгуулж, тус компанийн процессын дахин инженерчлэлийн чиглэлээр 20 гаруй жил ажилласан туршлага, Австрали, АНУ, Европын орнуудад үйл ажиллагаа явуулсан, өнгөрсөн хугацаанд дэлхийн төрийн болон хувийн хэвшлийн 400 гаруй томоохон байгууллагад процессын дахин инженерчлэлийг амжилттай хэрэгжүүлсэн туршлага, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхдээ өөрсдийн хөгжүүлсэн тусгай цахим системийг ашиглан семуляци хийж процессын дахин инженерчлэлээс гарсан үр дүнг нэвтрүүлэх, тасралтгүй хөгжүүлэлт, сайжруулалт хийдэг олон жилийн туршлагатай танилцан, мэргэжил, арга зүйн зөвлөгөө авсан. | | |
| 3.2. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д мэдээлэл хариуцагч байгууллагын шилэн индексийн тайлан илгээх, хүлээн авах, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх байдалд хяналт тавих, хяналтын тогтолцоог сайжруулах ажлыг зохион байгуулах; | Хянан баталгаажуулсан байгууллагын тоо | 575 | 250 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан нийтийн мэдээлэл хариуцагч байгууллагуудын жагсаалтыг аймаг, нийслэл, дүүрэг тус бүрээр ангилан гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 5600 гаруй мэдээлэл хариуцагч байгууллагын жагсаалттай тулгах ажлыг хийж гүйцэтгэн, Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д бүртгүүлэх байгууллагын жагсаалтыг шинэчлэн | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулах явцад хяналт тавьж ажилласан.<br>Засгийн газрын агентлаг, аймгийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харьяа байгууллагын нээлттэй мэдээллийн “Shilen.gov.mn” системд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар “Шилэн индекс”-ийн тайлан илгээсэн 1126 байгууллагын тайланг баталгаажуулан, олон нийтийн портал системд хэвлэн нийтлэх ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан.<br>“Шилэн индекс”-ийн тайланг нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр илгээсэн төрийн захиргааны төв байгууллага 92.61% (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 11 яам), төрийн захиргааны байгууллага 79.61% (23 агентлаг), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 60.6% (5 Засаг Даргын тамгын газар), нутгийн захиргааны байгууллага 78,84% (15 аймаг)-тай үнэлэгдсэн байна.<br>Газрын даргын баталсан хуваарийн дагуу 2025 оны 1 дүгээр улиралд Шилэн индексийн тайланг Нээлттэй мэдээллийн системд байршуулсан Засгийн газрын 25 агентлагийн тайланг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлангийн мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулахаар засварт буцааж, Гаалийн ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Монополын эсрэг газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохицуулалтын газар зэрэг нийт 8 агентлагийн тайланг хянан баталгаажуулж, олон нийтийн портал системд хэвлэн нийтэлсэн.<br>Мөн хуваарийн дагуу хариуцсан байгууллагаас Нийслэлийн Засаг даргын тамгын газрын тайланг засварт буцааж, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Төмөр замын газар системд тайлан илгээгээгүй учраас үнэлээгүй.<br>Авлигатай тэмцэх газраас 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр ирүүлсэн Мэдээлэл хүсэх тухай албан бичгийн хүрээнд Засгийн газрын "Шил ажиллагаа"-г хэрэгжүүлэх талаар хийсэн ажлын мэдээллийг нэгтгэн боловсруулж Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 04/203 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их хурлын нэгдсэн хуралдаанд "Шил ажиллагаа"-ны хэрэгжилтийг танилцуулахад шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах ажлын хэсэгт ажиллан холбогдох тайлан, мэдээ, мэдээллийг цаг хугацаанд гарган өгч ажилласан.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар байгуулагдсан Авлигатай тэмцэх "5ш" ажиллагааны хүрээнд "Шил ажиллагаа"-ны хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилэн индексийн үнэлгээг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зарлах үүрэг бүхий штабын үйл ажиллагааны 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд өгөх санал, Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д "Шилэн индекс"-ийн тайлан илгээх, тайланг үнэлж, хянан баталгаажуулах хугацааны төслийг боловсруулж шилэн индексийн үнэлгээг зарлах үүрэг бүхий штабт хүргүүлсэн.<br>Нээлттэй мэдээллийн (shilen.gov.mn) системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх үйлчилгээний ажлын даалгаварт тусгах саналыг боловсруулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны холбогдох мэргэжилтэнд Төрийн цахим шуудангаар 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр илгээсэн. | | |
| 3.3. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д мэдээлэл хариуцагч байгууллагын байршуулсан "Шилэн индекс"-ийн тайланг үнэлсэн, хянан баталгаажуулсан эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд хийх хяналт, шалгалтын удирдамж боловсруулах, хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх; | Хяналтын тоо | - | 1 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Авлигатай тэмцэх тухай хууль, Засгийн газрын 2022 оны Журам батлах тухай 201 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны Журам батлах тухай 352 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоол, 2023 оны Монгол Улсын Ерөнхий сайдын "Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 01 дүгээр албан даалгавар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааны хүрээнд "Шил ажиллагаа"-ны хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилэн индексийн үнэлгээг зарлах үүрэг бүхий Штабыг шинэчлэн байгуулах тухай А/46 дугаар тушаал зэрэг холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын | 01-12 | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн албан хаагчдын тайланг үнэлсэн, хянан баталгаажуулсан байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлэх хяналт, шалгалтын удирдамжийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргаар 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр батлуулсан. Хяналт, шалгалтын ажлыг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Гаалийн ерөнхий газар, Архангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Баянхонгор аймгийн ЗДТГ, Булган аймгийн Худалдан авах ажиллагааны газар, Говь-Алтай аймгийн Боловсролын газар, Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Дорноговь аймгийн аймгийн Засаг даргын Тамгын газар, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Орхон аймгийн нийгмийн даатгалын газар, Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын газар зэрэг нийт 12 байгууллагын 2024 оны жилийн эцсийн тайланд хяналт, шалгалт хийж гүйцэтгэсэн. | | |
| 3.4. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаа, үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэхэд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт | Зөвлөмжийн тоо | 26 | 3 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тавих, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, зөвлөмж хүргүүлэх; | | | | захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам", Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам", MNS 6984:2022 "Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих шаардлага", Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны "Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын брэндбүүк батлах тухай" А/13 дугаар тушаал, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журам"-ын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, үйл ажиллагааг сайжруулах, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлэх хяналт, шалгалтын удирдамжийг боловсруулан Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргаар батлуулан Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газарт хүргүүлсэн.<br>Батлагдсан удирдамжийн дагуу газрын мэргэжилтнүүдэд төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх, Багануур, Багахангай, Налайх дүүргийн нийт 36 хороонд байрлах ХУРДАН цэгийг хуваарилж, үүрэг чиглэл өгсөн.<br>Мөн сумдад байрлах 215 ХУРДАН цэгийн үйл ажиллагаанд 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэх хяналт, шалгалтын удирдамжийг боловсруулж, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хяналт, шалгалт хийгдэх цэгийн жагсаалтын хамт Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргаар 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр батлуулан удирдамжийг Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын Аймаг хариуцсан хэлтэст хүргүүлсэн. Хяналт, шалгалтыг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар баталсан "Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн үйл ажиллагааны түр журам"-ын хавсралтаар батлагдсан "ХУРДАН" цэгийн ажлын байранд тавигдах шаардлага, үнэлгээний хуудас, үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг хэмжих үнэлгээний хуудасны цэгийн тохижилт, цэгийн тоног, төхөөрөмжийн иж бүрэн байдал, цэгийн тоног, төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа эсэх, үйлчилгээний ажилтны мэдлэг, ур чадвар, мэдээллийн аюулгүй байдал зэрэг шалгуур үзүүлэлтийн дагуу хийж гүйцэтгэсэн.<br>Сум, хороонд байрлах ХУРДАН цэгийн үйл ажиллагаа, ажлын байранд тавигдах шаардлага, үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэх ур чадварт хийсэн хяналт, шалгалтын зөвлөмжийг хянаж, боловсруулалтад сайжруулалт хийж, тайлан, зөвлөмж хүргүүлэх албан бичгийг боловсруулан Чанар хяналтын газрын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 07, 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр 36 хороо, 215 суманд байрлах ХУРДАН цэгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн тайлан, 2 зөвлөмжийг Үйлчилгээний | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгдсэн төвийн зохицуулалтын газарт хүргүүлэн, тус газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.<br>Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журам"-ын ажлын байранд тавигдах тохижилт, тоног төхөөрөмж, нэмэлт хэрэгсэл, үйлчилгээний ажилтны хувцасны стандартад тавигдах 4 бүлгийн 49 шаардлага, цэгийн эмх цэгц, хэвийн үйл ажиллагааг үнэлэх үйлчилгээний цэгийн үзэмж, тохижилт, үйлчилгээний салбарын цэвэрлэгээ, мэдээллийн самбар зэрэг 3 бүлгийн 10 үзүүлэлт, үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх харилцах ур чадвар, хандлага үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх 4 бүлгийн 11 үзүүлэлт, нийт 70 шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулсан. | | |
| 3.5. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаанд хяналтын камераар хяналт хийх хуваарийг боловсруулан батлуулах, өөрийн хариуцсан цэгт хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах; | Хяналтын тоо | 14 | 3 | Төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа нийслэл дэх 11 цэгийн үйл ажиллагаанд хяналтын камераар хяналт тавих хуваарийг боловсруулан Чанар хяналтын газрын даргаар батлуулан, хуваарийн дагуу хяналт, шалгалт хийх талаар газрын албан хаагчдад үүрэг чиглэл өгч ажилласан.<br>Мэдээллийн аюулгүй байдлын аудитаас өгөгдсөн зөвлөмжийн дагуу ХУРДАН цэгүүдийн камерын хяналттай холбоотой нэгдсэн шийдэл, шийдвэр гаргах, | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | камерын бичлэгийг хуульд нийцүүлсэн байдлаар хадгалдаг байх ажлыг хэрэгжүүлэх үүднээс Чанар хяналтын газарт камер хяналтыг байршуулах ажлын хүрээнд ашиглагдах 80-85, 60 инчийн дэлгэц зэрэг тоног төхөөрөмж худалдан авахаар боловсруулсан жагсаалтыг хянаж холбогдох газарт хүргүүлсэн. | | |
| 3.6. | Газрын үйл ажиллагаа, хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор хүргэх "ХУРДАН" цэгт мэдээллийн аюулгүй байдлын аудитыг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдээр хийлгэх, зөвлөн туслах үйлчилгээ авах ажлыг зохион байгуулах; | Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэсэн тоо | - | 5 | Тус газрын үйл ажиллагаа, хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор хүргэх "ХУРДАН" цэгт мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдээр хийлгэж гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/98 дугаар тушаалаар байгуулсан.<br>Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, 17.1.7 дахь заалт, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/74 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам", Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан 2024 оны А/30, А/148 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал"-ыг үндэслэн мэдээллийн аюулгүй байдлын аудитыг Прокактив солушн ХХК-иар гүйцэтгүүлж тайланг хүлээн авч, зөвлөмжийн холбогдох үл нийцлийг засч | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайжруулж, мэдээллийн аюулгүй байдлын аудитын баталгаажуулалтын үр дүн, дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, хугацааг тодорхойлон холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.<br>Мэдээллийн аюулгүй байдлын аудитын талаар сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17, 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, сургалтад газрын албан хаагчид болон аймаг дахь мэдээлэл технологийн ажилтнууд нийт 83 албан хаагч хамрагдсан.нийт 83 албан хаагч хамрагдсан. | | |
| 3.7. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хөгжүүлэлтийн явцад хяналт тавих, ХУРДАН цэгийн техник тоног төхөөрөмж, программ хангамж, сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлэх; | Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ | - | 1 | Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтын дагуу кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх гэрээний төслийг боловсруулан бэлэн болгосон бөгөөд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх асуудал хүлээгдэж байна. | 06-12 | 50 |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ: 4 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ** | | | | | | | |
| 4.1. | Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль, тогтоолын төсөлд санал өгөх; | Саналын тоо | - | 1 | Нээлттэй мэдээллийн (shilen.gov.mn) системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх үйлчилгээний ажлын даалгаварт тусгах санал, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын Шилэн индексийн тайланг үнэлэх шалгуур үзүүлэлтийг өөрчлөх санал, “Шилэн индекс”-ийн тайлангийн 5 бүлэг 87 шалгуур үзүүлэлтийг файл, зурагтай байх эсэх дээр санал боловсруулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны холбогдох мэргэжилтэнд Төрийн цахим | 01-12 | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шуудангаар 2025 оны 03 дугаар сарын 10, 06 дугаар сарын 05, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус илгээсэн.<br>Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их хурлын нэгдсэн хуралдаанд “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг танилцуулахад шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах ажлын хэсэгт ажиллан холбогдох тайлан, мэдээ, мэдээллийг цаг хугацаанд гарган өгч ажилласан. | | |
| 4.2. | Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлуулж, биелэлтийг хангах; | Журмын тоо | - | 1 | Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд “Хяналт шалгалтын журам”, “Бусдаар ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх журам” зэрэг нийт 3 журмын боловсруулсан төслийг хянах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар баталсан Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” цэгийн үйл ажиллагааны түр журмын төслийг шинэчлэн боловсруулсан.<br>Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн үйл ажиллагааны түр журам”- ын:<br>• ажлын байранд тавигдах тохижилт, тоног төхөөрөмж, нэмэлт хэрэгсэл, үйлчилгээний ажилтны хувцасны стандартад тавигдах 4 бүлгийн 49 шаардлага<br>• цэгийн эмх цэгц, хэвийн үйл ажиллагааг үнэлэх үйлчилгээний цэгийн үзэмж, тохижилт, үйлчилгээний салбарын цэвэрлэгээ, мэдээллийн самбар зэрэг 3 бүлгийн 10 үзүүлэлт<br>• үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур | 01-12 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх харилцах ур чадвар, хандлага үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх 4 бүлгийн 11 үзүүлэлт, нийт 70 шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, газар, хэлтсийн дарга нараас санал авч, тушаалын төслийг боловсруулж бэлэн болгосон.<br>Нийт 4 журмын төслийг хянаж боловсруулсан. | | |
| 4.3. | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах; | Хүлээлгэн өгсөн баримтын тоо | - | 2 | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмыг баримтлан 2025 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр хуваарилагдаж ирсэн 12 бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг албан бичгээр хүргүүлсэн. Мөн стандарт, журмыг баримтлан Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр нийт 108 албан бичгийг холбогдох байгууллагуудад илгээсэн.<br>Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Чанар хяналтын газрын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, Захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн.<br>Батлагдсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хяналт, шалгалтын тайлан, үйлчилгээний ажилтантай холбоотой санал, хүсэлт, гомдлын бүртгэл, төрийн байгууллагуудын “Нээлттэй мэдээллийн систем”-д байршуулж, нийтэлсэн мэдээлэлд үнэлгээ хийсэн ажил, төрийн байгууллагуудаас хүн, хуулийн этгээдэд | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлж буй төрийн үйлчилгээнд дахин загварчлал хийх ажлын хүрээнд хийсэн ажлын албан хэрэгт үүсэж хөтлөгдсөн баримт бичгийг байгууллагын архивд хүлээлгэн өгсөн. | | |
| 4.4. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах; | Хэрэгжилтийн хувь | 0% | 100% | Тайлант хугацаанд газрын даргаас өгсөн 25 үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, эргэж тайлагнаж ажилласан. | 01-12 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны А/53 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах (Эцэг, эхийн зөвлөл); | Арга хэмжээний тоо | 1 | 4 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын Эцэг эхийн зөвлөлийн хурлыг нийт 8 удаа зохион байгуулж, төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулах, 0-18 насны хүүхдийн судалгаа авах, гэр бүлийг хамруулсан спортын арга хэжмээ зохион байгуулах "Хүүхдийн баяр"-ын арга хэмжээг уггтан зохион байгуулах арга хэмжээний талаар хэлэлцсэн.<br>Эцэг эхийн зөвлөлийн ажиллах журам, төлөвлөгөөний төслийг шинэчлэн боловсруулж батлуулсан.<br>Тухайн ажлын хүрээнд Монголын үндэсний зуслангийн холбооны удирдах ажилтнуудтай уулзалт зохион байгуулж, нийт албан хаагчдын 0-18 нас хүртэлх хүүхдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж, "Хүүхдийн баяр"-ын арга хэмжээг угтан зохион байгуулах уралдаан, тэмцээний удирдамжийг боловсруулсан.<br>Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь хэсэгт заасан | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Хүүхдийн баяр”-ыг угтан хүүхэд багачуудын бүтээлч сэтгэлгээ, төсөөлөн бодох чадвар, уран зургийн авьяасыг дэмжих, цахим орчны талаарх ойлголтыг нь уран бүтээлээр дамжуулан илэрхийлэх, зөв мэдээлэлтэй болоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт албан хаагчдын хүүхдүүдийн дунд “Цахим ертөнц - Миний нүдээр” гар зургийн уралдааныг зохион байгуулж, уралдаанд нийт 29 хүүхдийн бүтээл ирсэн.<br>Уралдаанд ирүүлсэн бүтээлийг 3–5 нас (цэцэрлэгийн нас), 6–11 нас (бага анги), 12–15 нас (дунд анги), 16–18 нас (ахлах анги) зэрэг 4 насны ангилал тус бүрээр шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагнал, батламжаар шагнах арга хэмжээг “Хүүхдийн баяр”-ын өдрийн арга хэмжээний үеэр зохион байгуулсан. | | |
| 2. | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны А/99 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах; | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 1 | “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлын хэсгийг газрын даргын 2023 оны А/99 дүгээр тушаалаар байгуулсан.<br>Тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Удирдлагын хөгжил судлалын академи” ТББ-ын төлөөлөлтэй 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хамтарсан уулзалт зохион байгуулж, тус байгууллагаас ажлын хэсгийн гишүүд, газрын нэгжийн удирдлагуудад стратеги | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөө боловсруулах аргачлал, стратеги төлөвлөгөөний орчны шинжилгээ хэрхэн хийх талаар танилцуулга хийсэн.<br>Төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд нийт газрын албан хаагчдын асуудлын модны шинжилгээ, SWOT, PESTEL, Мексоны шинжилгээний аргуудаар авсан асуумжийг нэгтгэн Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.<br>Стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | | |
| 3. | Процессын дахин инженерчлэл зангиагүй уулзалтаас гарсан санаануудаар танилцуулга бэлтгэх; | Танилцуулгын тоо | - | 1 | Процессын дахин инженерчлэл зангиагүй уулзалтын үеэр оролцогчдоос гаргасан саналын дагуу танилцуулгыг бэлтгэн 2025 оны 1 дүгээр сард Чанар хяналтын газрын даргад танилцуулсан. | 01-12 | 100 |
| 4. | Чанар хяналтын газраас 2025 онд хийгдэх ажлын танилцуулга бэлтгэх; | Танилцуулгын тоо | - | 1 | Танилцуулгыг боловсруулан танилцуулсан. | 01-12 | 100 |
| 5. | Хяналт, шалгалтын чиглэлээр 2024 онд хийсэн ажлын нэгдсэн тайланг боловсруулах; | Тайлангийн тоо | 1 | 1 | Хяналт, шалгалтын чиглэлээр 2024 онд хийсэн ажлын нэгдсэн тайланг боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр танилцуулсан. | 01-12 | 100 |
| 6. | Хороонд байрлах ХУРДАН цэгт хийсэн хяналт, шалгалтын тайлан танилцуулах; | Тайлан, зөвлөмжийн тоо | 1 | 1 | Хороонд байрлах 36 ХУРДАН цэгт хийсэн хяналт, шалгалтын тайланг боловсруулан нэгтгэж, 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар дотоод албан бичгээр Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газарт хүргүүлсэн. | 01-12 | 100 |
| 7. | Мэдээллийн аюулгүй байдлын аудитын талаар ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг нийт газрын дарга нарт албан мэйлээр хүргүүлэх; | Мэдээлэл хүргүүлсэн тоо | - | 1 | Мэдээллийн аюулгүй байдлын аудитын талаар ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр албан мэйлээр хүргүүлсэн. | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Агентлагийн албан хаагчдад сургалт хийх хуваарь гаргах; | Боловсруулсан хуваарийн тоо | 1 | 1 | Засгийн газрын агентлаг, аймгийн ЗДТГ-т зохион байгуулах Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn) 2.0 сургалтын хуваарийн боловсруулан газрын даргаар батлуулсан | 01-12 | 100 |
| 9. | Аймаг, нийслэл рүү явуулсан киоскийн албан бичгийн судалгааг авч дуусгах ажлыг Систем нэгтгэлийн хэлтэстэй хамтран 5 дугаар сард багтааж дуусгах; | Судалгааны тоо | - | 1 | Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн Засаг даргын тамгын газар, 9 дүүрэг, 21 аймаг, 37 агентлаг, нийт 68 байгууллагад киоск төхөөрөмж ашиглалтын судалгаа авах албан бичиг явуулж, 52 байгууллага судалгаа ирүүлсэн. Үүнээс: Киоск төхөөрөмж ашигладаггүй 22 байгууллага, киоск төхөөрөмж ашигладаг 30 байгууллагын нийт 279 киоскийн судалгааг нэгтгэж ажилласан.<br>Аймаг, нийслэл, Засгийн газрын агентлаг руу албан бичиг явуулсан жагсаалтыг гарган Систем нэгтгэлийн хэлтэст гаргаж өгсөн. Уг жагсаалтын дагуу тухайн байгууллагуудтай судалгааг ирүүлэх асуудлаар утсаар ярьж судалгааг гүйцээж авах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 01-12 | 100 |
| 10. | И Монгол Академи Улсын төсөвт үйлдвэрийн газартай shilen.gov.mn, gov.mn-тэй холбох асуудлаар уулзалт зохион байгуулах; | Уулзалтын тоо | - | 2 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, И Монгол Академи Улсын төсөвт үйлдвэрийн газар, Аствишн ХХК-ийн холбогдох албан хаагчидтай танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан 2 удаагийн хуралд оролцсон. Телеграмм группт нэгдсэн. | 01-12 | 100 |
| 11. | Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлэх Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн товч тайланг боловсруулах, хүргүүлэх; | Тайлангийн тоо | - | 1 | Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн албан бичгийн дагуу хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажил, мэдээ, мэдээллийг боловсруулан нэгтгэж, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 01/563 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Сайдын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" А/59 дүгээр тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг гаргаж Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлэх; | Тайлангийн тоо | - | 1 | "Үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" А/59 дүгээр тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг боловсруулан нэгтгэж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 01/349 дүгээр албан бичгээр хүргүүлсэн<br>Мөн тайланг хураангуй хэлбэрээр боловсруулан 2025 оны 05 дугаар 15-ны өдөр албан мэйлээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам руу хүргүүлсэн | | |
| 13. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn) 2.0 хувилбарын "Шилэн индекс"-ийн тайланд хийсэн үнэлгээний талаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас 2025 оны 1 дүгээр удиралд хийсэн ажлын тайланг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлэх; | Тайлангийн тоо | 3 | 1 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас 2025 оны 1 дүгээр удиралд "Шилэн индекс"-ийн тайланд хийсэн үнэлгээний ажлын тайланг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн | 01-12 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1. | Байгууллагаас болон бусад газраас зохион байгуулах сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | 4 | 4 | • Мэдээллийн аюулгүй байдлын аудитын талаар зохион байгуулсан сургалт;<br>• АЙ ЭМ ЭС ЭЙ ХХК-аас зохион байгуулж буй чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001:2022 стандартуудыг нэвтрүүлэх сургалтад хамрагдсан.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яам, | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сангаас хамтран 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 11-ний өдрүүдэд зохион байгуулсан "Цахим эрүүл мэнд" салбар дундын хуралд оролцсон. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Чанар хяналтын газрын чанар хяналтын ахлах мэргэжилтэн ................................ / Д.Оюунчимэг / 2025.06.10